



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/05

Эрдэнэт


**Цэргийн дүйцүүлэх алба хаах
иргэдийн тоог тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн “Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 279 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2023 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог 20 хүнээр тогтоосугай.

2. Аймгийн 2024 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарын саналаа хуулийн хугацаанд Батлан хамгаалах яаманд хүргүүлж ажиллахыг аймгийн Цэргийн штабын дарга, дэд хурандаа Б.Оюунтүлхүүрт даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ